

**БАТЛАВ
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД**

**БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Д.ЦОГТБААТАР

Ц.НЯМДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ,
ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын иргэний гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гаргах этгээдийг тодорхой болгох, хэрэгждэггүй зарим заалтыг хүчингүй болгох, насанд хүрээгүй иргэн, гадаадад хувийн хэргээр цагаачлах асуудлаар бусад хуультай зөрчилдсөн зохицуулалтыг нийцүүлэх зорилгоор Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг боловсруулахаар тусгагдсан.

2.Хуулийн төсөл боловсруулах практик шаардлага

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль нь 1993 онд батлагдсанаас хойш нийт 12 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 30 орчим заалтад холбогдох өөрчлөлт оруулж байсан хэдий ч хуулийн зүйл, заалт хоорондын уялдаа холбоо хангалтгүй, нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй дараахь асуудлууд тулгарч байна.

1.Монгол Улсын иргэн хилийн чанадад хувийн хэргээр зорчих, суралцах, хөдөлмөр эрхлэх, жуулчлах, оршин суух иргэдийн тоо жил бүр өсөн нэмэгдэж байна. Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуульд гадаадад удаан хугацаагаар суугаа болон цагаачлан суугаа иргэн нь хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газар болон консулын газар хаягийн бүртгэл хийлгэж байх үүрэгтэй, түр хугацаагаар зорчиж байгаа иргэд бүртгэл хийлгэж болохоор тусгасан байдаг. 2017 оны байдлаар Монгол Улсын 144500 иргэн 75 улсад байнга оршин сууж ажил хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн мэдээлэл байгаа боловч бодит байдал дээр нэгдсэн тоо бүртгэл

нь тойм төдий байна. Учир нь иргэд сайн дураар ирж бүртгүүлдэггүй, албадах ямар ч боломж байхгүй бөгөөд тухайн хилийн чанадад байгаа дипломат төлөөлөгчийн газарт ирж ямар нэг байдлаар төрийн үйлчилгээ авсан иргэдийн тоон дээр суурилсан байдаг, түүнчлэн Дипломат төлөөлөгчийн газар болон Консулын газар байхгүй улсад оршин суугаа болон зорчиж байгаа иргэдийн мэдээлэл байх боломжгүй зэрэг асуудал байсаар байна.

Иймд хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэлийн нэгдсэн системийг боловсронгуй болгох, бүртгэлтэй иргэд, ялангуяа их, дээд сургуульд суралцаж байгаа иргэдээ дэмжих, тэднийг шаардлагатай ажлын байраар хангах зорилгоор тэдгээрийн мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллагууд, ажил олгогчдод нээлттэй солилцох боломжийг бүрдүүлж, хилийн чанадад байгаа дипломат төлөөлөгчийн газрыг хилийн чанадад байгаа иргэдээ бүртгэх, Монгол Улсын төрийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын бодлогыг Монгол Улсын бүх иргэнд жигд хүртээмжтэй хамруулахад санаачлагатай ажиллах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Түүнчлэн хүүхдийн эрхийг хамгаалах зорилгод нийцүүлэхээр хүүхдийг улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

2.Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх буюу хилийн хоригтой холбоотой асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа тус хуульд үндэслэл, хугацааг тусгасан боловч хилийн хоригийн талаарх мэдээллийг бүрдүүлэхэд эрх бүхий байгууллагуудын тусдаа шийдвэрээр баталсан журмууд хэрэгждэг, нэгдсэн бүртгэл байхгүй тул уг үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бий болгох шаардлага байсаар байна.

3.Монгол Улсад гадаадад цагаачлах иргэний хүсэлтийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх төрийн захиргааны байгууллага хүлээн авч шийдвэрлэх хуулийн зохицуулалт үйлчилж байгаа ч практикт хэрэгжихгүй байна. Тухайн орны цагаачлалын асуудал эрхэлсэн байгууллагын зөвшөөрлийг нэгэнт авсан Монгол Улсын иргэн Монгол Улсаас дахин цагаачлах зөвшөөрөл хүсэх нь олон улсын жишигт нийцдэггүй, практикт хэрэгжих боломж муу байгаагаас иргэд тус байгууллагад хандахаа больсон байна. Тухайлбал: өнөөдрийн байдлаар Монгол Улсын иргэдийг гадаадад цагаачлах асуудлыг шийдвэрлэх тодорхой чиг үүргийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд 2001 онд 2, 2002 онд 4 нийт 6 иргэнд цагаачлах зөвшөөрөл олгосон байна. Иймээс хуульд тусгагдсан зарим зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжих боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар хилийн чанадад байгаа иргэдэд туслах сангийн талаар зохицуулсан боловч түүнийг ямар үйл ажиллагаанд зарцуулах талаарх зохицуулалт байхгүй байна. Иймд хилийн чанадад байгаа иргэдэд туслах сангийн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагааг Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолоор баталсан журмаар зохицуулж байгааг өөрчилж, зайлшгүй шаардлагатай зарчмын зохицуулалтыг хуульд тусгах замаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Түүнчлэн гадаадад иргэдийг эх орондоо буцан ирэхийг дэмжих талаар төрөөс хэрэгжүүлэх тодорхой бодлого, зохицуулалтын суурь зарчмыг бий болгох шаардлагатай байна.

6.Тус хууль нь зөвхөн хувийн хэргээр зорчих, цагаачлах иргэдэд хамааралтай байхаар зохицуулжээ. Гэвч практикт дээр зөвхөн хувийн хэргээр зорчих иргэдэд хамааралтай байхаар бус ялангуяа зорчих эрхийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлэх асуудал нь нь хувийн болон албан хэргээр зорчиж байгаа иргэн аль алинд нь хамааралтай байхаар үйлчилж иржээ. Хууль тогтоомжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтад хуулийн төслийн нэр нь хуулийн төслийн агуулгыг бүрэн илэрхийлсэн байна. (агуулгыг хагас дутуу, эсхүл хэтрүүлж илэрхийлж болохгүй) гэж заасан. Иймээс хуулийн төслийн нэр нь зөвхөн хувийн хэргээр зорчиход хамааралтай байхаар зохицуулсныг өөрчилж, гадаадад хувийн болон албан хэргээр зорчих Монгол Улсын бүх иргэнд хамааралтай байдлаар боловсруулах шаардлагатай байна.

Иймд хуулийн төслийн нэрийг Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хууль гэж өөрчлөн боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад нийт хуулийн 50-иас дээш хувьд өөрчлөлт оруулахаар байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах шаардлагатай бөгөөд хуулийн төсөлд дараахь асуудлуудыг тодорхой тусгана.

1.Хуулийн нийтлэг үндэслэл болох хуулийн зорилтын тодорхойлж, Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, нэр томъёоны тодорхойлолтыг тусгана.

2.Монгол Улсын иргэн гадаадад зорчихдоо тодорхой үүрэг, хариуцлагатай байх, түүнчлэн хуульд заасан тохиолдолд тусламж, дэмжлэг авах, төрийн үйлчилгээг дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан авах зэрэг эрх, үүргийн талаар тусгана.

3.Монгол Улсын иргэн гадаадад цагаачлахад бүрдүүлэх баримт бичиг, цагаачилсан иргэдийн нэгдсэн бүртгэлийг харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хөтлөх асуудлын талаар тусгана.

4.Насанд хүрээгүй хүн, эрх зүйн чадамжгүй хүний гадаадад зорчих, цагаачлахтай холбоотой харилцааг тусгана. Энэ хэсэгт хүүхдийн хилийн гадна үлдээж буцан ирсэн тохиолдолд үлдээсэн шалтгаан, тайлбар, баримтыг хил хамгаалах байгууллагад заавал гаргаж өгөх зэрэг асуудлыг тусгана.

5.Хилийн чанадад байгаа иргэдэд туслах сангийн талаар, сангаас тусламж дэмжлэг үзүүлэх хэлбэрийг тодорхой тусгаж, сантай холбоотой нарийвчилсан журмыг Засгийн газрын тогтоолоор батлах тухай эрх шилжүүлсэн зохицуулалтыг тусгана.

6.Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, цуцлах үйл ажиллагааг нарийвчлан тусгах, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн,

сунгасан, цуцалсан талаарх мэдээллийн нэгдсэн сан байгуулах, эрх бүхий байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг батлах эрхийг Засгийн газарт олгох зохицуулалтыг тусгана.

7.Гадаадад оршин суугаа иргэдийг эрх орондоо буцан ирэхийг дэмжих, төрөөс хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотой суурь зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн давхардал, хийдэл арилж, Монгол Улсын иргэний эрх хангагдаж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд тодорхой хувь нэмэр болно.

Монгол Улсын иргэний хилээр гарах эрхийг түдгэлзүүлсэн мэдээллийн солилцох, хилийн хоригт бүртгэх асуудлыг хуулиар эрх олгогдоогүй эрх бүхий этгээдүүдийн баталсан журмаар зохицуулж байсныг өөрчилж, шаардлагатай журам батлах эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгаснаар хилийн боомтоор гарахыг түдгэлзүүлсэн иргэнийг хилийн хоригт хэрхэн бүртгэх, харилцан мэдээлэл солилцох асуудал нэгдсэн журмаар зохицуулагдах боломж бүрдэнэ.

Түүнчлэн гадаад улсад суугаа иргэдийн тоо бодитой бүрдэх, түүнд үндэслэн тэдгээрийн эрхийн хамгааллын асуудал сайжирч, гадаадад байгаа иргэдийн талаарх мэдээлэл нь Монгол Улсын төрийн байгууллага, ажил олгогч хуулийн этгээдэд нээлттэй ашиглах, харилцан мэдээлэл солилцох, ялангуяа гадаадад суралцаж байгаа иргэдийг эх орондоо ирж ажлын байраар хангагдах боломжийг нэмэгдүүлнэ.

Хилийн чанадад тусламж, дэмжлэг шаардлагатай болсон иргэдийг хуулийн дагуу Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр дэмжин туслах үйл ажиллагааг тодорхой тусгаснаар хилийн чанадад байгаа иргэд болон хэрэгжүүлэгч байгууллагад илүү ойлгомжтой, тодорхой болно.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулна.